



**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
2021 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН**

**Даланзадгад
2021 он**

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2021 ОНЫ ТАЙЛАНГИЙН АГУУЛГА

1. Бодлогын зорилтыг хангах талаар

- 1.1. Удирдлага зохион байгуулалт
- 1.2. Тайлан мэдээ, албан бичиг
- 1.3. Санхүү, үнэт цаасны тооцоо, тайлан мэдээ

2. Иргэний улсын бүртгэл

- 2.1. Иргэний гэр бүлийн байдлын бүртгэл, шилжилт хөдөлгөөний бүртгэл
- 2.2. Гадаадад зорчих эрхийн бүртгэл
- 2.3. Иргэний үнэмлэх олгох ажил
- 2.4. Иргэний бүртгэлийн архивийн лавлагаа, тайлан мэдээ

3. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл

- 3.1. Иргэн, хуулийн этгээдийн өмчлөх эрхийн баталгаажуулалт, өөрчлөлт, түүнтэй холбоотой бусад эрхийн бүртгэл, лавлагаа, тайлан мэдээ
- 3.2. Эд хөрөнгө өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн бүртгэл
- 3.3. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн талаарх мэдээллийн сан, нотлох баримтаар хувийн хэрэг бүрдүүлж, иргэн, хуулийн этгээд болон хууль хяналтын байгууллагыг лавлагаа, мэдээллээр хангах чиглэлээр

4. Хуулийн этгээдийн улсын бүртгэл

- 4.1. Хуулийн этгээдийн улсын бүртгэл, лавлагаа, тайлан мэдээ

5. Програм хангамжийн талаар

6. Улсын бүртгэлийн хяналт шалгалт

- 6.1 Хяналт шалгалт - Иргэний бүртгэлийн чиглэлээр
- 6.2 Хяналт шалгалт - Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр
- 6.3 Хяналт шалгалт - Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр
- 6.4 Бусад ажил үйлчилгээ

7. Удирдлагын багт тавих санал

БОДЛОГЫН ЗОРИЛТЫГ ХАНГАХ ТАЛААР

1.1 УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

Өмнөговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь УБЕГазрын даргын 2018 оны 07 дугаар сарын 20 ны өдрийн Б/07 тоот тушаалаар батлагдсан орон тооны дагуу 2019 онд Улсын бүртгэлийн хэлтсийн дарга 1, хяналтын улсын байцаагч 1, тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч 2, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч 2, иргэний улсын бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч 2, хуулийн этгээдийн улсын бүртгэгч 1, архивч 2, ахлах нягтлан бодогч 1, нярав, мэдээллийн технологийн ажилтан 1, Архив, бичиг хэргийн ажилтан 1, гэрээт албан хаагч үйлчлэгч 2, жижүүр 2, 15 сумын 15 улсын бүртгэгч нийт 34 албан хаагчтайгаар Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний бүртгэлийн тухай хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам, Зөрчлийн тухай хууль, Зөрчил хянан шийдвэрлэх тухай хууль, Улсын бүртгэлийн ерөнхий газар болон орон нутгийн удирдлагаас өгсөн үүрэг, даалгавар, удирдамж чиглэл, тушаал, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хяналтад авч бүртгэлийг хөтлөн хэрэгжилтийг өдөр тутмын ажил, үйлчилгээнд бүрэн хэрэгжүүлж, иргэн, хуулийн этгээдэд эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэл, иргэний улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг орон нутагт эрхлэн зохион байгуулах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэн Улсын бүртгэлийн үйлчилгээг үнэн зөв, ил тод, түргэн шуурхай, шударга, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэн үйлчиллээ.

МЭДЭЭЛЭЛ, СУРГАЛТ.

➤ 2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр АЗДТГ-ын ХШГ-с “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах” арга зүйгээр хангахад чиглэсэн онлайн сургалтанд ИУБТасгийн улсын бүртгэгч Ч.Пүрэвдавга, Архив, Бичиг хэргийн ажилтан О.Жижигчулуун нар оролцсон.

➤ 2021.01.18-ны өдөр аймгийн аймгийн ГХБХБ-ын газрын удирдлага, мэргэжилтэнүүдтэй шинээр мөрдөж буй хаягийн тогтоолыг хэрхэн хэрэгжүүлэх, сумдын газрын даамлуудаас ирүүлж байгаа газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн нотлох баримтад анхаарах асуудлын талаар уулзалт зохион байгуулсан.

➤ 2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр УБЕГГазар, ХЗДХЯ-с орон нутаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн сумын улсын бүртгэгч нарыг “Улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд мэдээлэл хүлээн авах, хадгалах, түүний аюулгүй байдлыг хангах журам”, “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах” арга зүйгээр хангахад чиглэсэн онлайн сургалтанд хэлтсийн төрийн захиргааны бүх албан хаагчид оролцсон.

➤ 2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр УБЕГДарга “Бодлого төлөвлөлт, цаг үеийн мэдээлэл” онлайн сургалтанд Хэлтсийн дарга 2 ахлах оролцсон.

➤ 2021 оны 02 дугаар сарын 24-ний өдөр Өмнөговь аймгийн татварын хэлтсээс “Цахим тайлан гаргах” талаар тэнхимийн сургалт зохион байгуулж хэлтсийн бүх алба хаагчид хамрагдсан.

➤ 2021 оны 03 дугаар сарын 03-ны өдөр Өмнөговь аймаг дахь Цагдаагийн газраас “Архи ба Амьдрал” сэдэвт цахим онлайн сургалтанд хэлтсийн бүх алба хаагчид хамрагдсан.

➤ 2021 оны 03 дугаар сарын 09-ний өдөр Монгуулийн ерөнхий хорооноос “МУЕС-ийн тухай хуулийн” талаар онлайн сургалтанд Хэлтсийн дарга Ч.Энхмөнх, ИУБТасгийн дарга Б.Должинсүрэн нар оролцсон.

➤ 2021 оны 03 дугаар сарын 18-ны өдөр Төрийн албаны зөвлөлөөс “Алба хаагчдын оролцоог нэмэгдүүлэх ” сэдэвт багц онлайн сургалтанд алба хаагчид хамрагдсан.

➤ 2021 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр УБЕГ-с E-Mongolia иргэний үнэмлэх, гадаад паспорт, лавлагаа мэдээллийн талаар онлайн сургалтанд хамрагдсан.

➤ 2021 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр Төрийн албаны зөвлөлөөс “Төрийн албан дахь бодлогын шинэтгэл ба боломжууд” сэдэвт онлайн сургалтанд Хэлтсийн алба хаагчид бүгд хамрагдсан.

➤ 2021 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр Сонгуулийн ерөнхий хорооноос “МУЕС-ийн тухай” цахим сургалтанд Хэлтсийн дарга Ч.Энхмөнх, ИУБТасгийн дарга Б.Должинсүрэн нар оролцсон.

➤ 2021 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр УБЕГ-ын “Санхүүгийн аудит, Шилэн дансны хэрэгжилт, стратеги төлөвлөгөө”-ний талаар онлайн сургалтанд Хэлтсийн дарга Ч.Энхмөнх, ИУБТасгийн дарга Б.Должинсүрэн, Ахлах нягтлан бодогч С.Батхүү нар оролцсон.

➤ 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр АЗДТГ, ТЗУХэлтэс “Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн” тухай онлайн сургалтанд Хэлтсийн дарга Ч.Энхмөнх оролцсон.

➤ 2021 оны 05 дугаар сарын 11-с 2021 оны 05 дугаар сарын 13-ны өдрүүдэд УБЕГ-с “Итгэмжлэгдсэн ажилтаны” онлайн сургалтанд 15 сум болон Хэлтсийн бүх алба хаагчид хамрагдсан.

➤ 2021 оны 06 дугаар сарын 01-с 2021 оны 06 дугаар сарын 05-ны өдөр УБЕГ-с Л.Өнөртуяагаар ахлуулсан ажлын хэсэг “Итгэмжлэгдсэн ажилтаны” танхимын сургалтанд 15 сум болон Хэлтсийн бүх алба хаагчид хамрагдсан.

➤ 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдөр Аймгийн сонгуулийн хорооноос “Сонгогчийн нэрсийн жагсаалт”-ын талаар онлайн сургалтанд хамрагдсан.

➤ 2021 оны 06 дугаар сарын 06-ны өдөр ЗГХЭГазараас “үр дүнд суурилсан бодлого төлөвлөлт” сэдэвт онлайн сургалтанд Хэлтсийн алба хаагчид хамрагдсан.

➤ 2021 оны 05 дугаар сарын 10-ны өдөр УБЕГ-с “МУЕС-ийн тухай хуулийгш хэрэгжүүлэх ажлын хүрээнд зохион байгуулах, чиглэл өгөх” онлайн сургалтанд Хэлтсийн дарга Ч.Энхмөнх, ИУБТасгийн дарга Б.Должинсүрэн нар оролцсон.

➤ 2021 оны 06 дугаар сарын 07-ны өдөр Сонгуулийн ерөнхий хорооноос “Өмнөговь аймгийн 61 хэсэгт 1185 сонгогч зөөврийн битүүмжилсэн саналын хайрцагаар санал өгөх ” тухай онлайн сургалтанд Хэлтсийн дарга Ч.Энхмөнх, ИУБТасгийн дарга Б.Должинсүрэн ЭХЭУБТасгийн дарга Б.Азжаргал, Хяналтын улсын байцаагч нар оролцсон.

➤ 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдөр Төрийн албаны зөвлөл, Архивын ерөнхий газраас хамтарсан “Төрийн албаны тухай болон Архив, Албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн хэрэгжилт” сэдэвт арга зүйн онлайн сургалтанд Архив, Бичиг хэргийн ажилтан О.Жижигчулуун хамрагдаж мэдээлэл авч ажилласан.

➤ ЦАГ ҮЕИЙН АЖИЛ

➤ 2021 оны 03 дугаар сарын 16 ны өдөр “Олон улсын хэрэглэгчдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг угтан улсын бүртгэлийн үйлчилгээний цаг үеийн мэдээ, мэдээллийг олон нийтийн сүлжээгээр иргэдэд хүргэж ажилласан.

➤ Шинэ төрлийн коронавирусээс урьдчилан сэргийлэх зорилгоор үйлчилгээний танхимд 2 метрийн зайнаас үйлчлүүлэх тэмдэг тэмдэглэгээг нааж иргэдэд мэдээлэл өгч, иргэдийн биеийн халуун хэмжин өдөр бүр бүртгэлжүүлж ажиллаж байна.

➤ Үйлчилгээний танхимд Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч, Хуулийн этгээдийн улсын бүртгэгч, Иргэний улсын бүртгэлчийн үйлчилгээний цонхонд иргэд үйлчилгээ авах дугаар бүхий шилэн сав байршуулж, шалан дээр **!!!COVID 19 !!! 1-2 метр** зай барь гэсэн 10 тэмдэглэгээг нааж, иргэдэд зохих ёсны

шаардлага тавьж, албан хаагчид болон иргэдийг мэдээллээр тогтмол ханган ажиллаж байна.

- 2021.04.16 ны өдөр аймгийн ЭМГазрын Зоонозын өвчин судлалын төвөөр хэлтсийн 1134 м.кв талбайд ариутлгал хийлгэж ажилласан.

- 2021.07.7, 2021.07.23-ны өдрүүдэд Аймгийн шуурхай штаб дээр Мэдээлэл технологийн ажилтан О.Эрдэнэбат, ЭХЭУБТасгийн Архивч А.Цэцэгжаргал, ИУБТасгийн улсын бүртгэгч З.Хасар, Б.Баясгалан нар шуурхай штабын утсаар иргэдэд мэдээлэл өгч ажилласан.

- 2021 оны 02 сараас 2021 оны 05 дугаар сар хүртэлх хугацаанд нийт 4 удаа Аймгийн постонд хэлтсийн бүх алба хаагчид жижүүрлэж ажилласан.

- 2021 оны 03 дугаар сарын 31-ны өдөр Хэлтсийн бүх алба хаагчид Коронавирусын эсрэг вакцины 1-р тун 2-р тунд хамрагдсан.

- 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр Өмнөговь аймгийн Даланзадгад сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал /сумын Улаан загалмайн анхан шатны хороо/ - аас зохион байгуулсан "Нийгмийн түншлэл"-ийг дэмжин хөгжүүлэх зорилготой хүмүүнлэгийн нэг сарын аянд нэгдэж Манлай сумын малчин Д.Бямбаагийн гэр бүлд, Улсын бүртгэлийн хэлтсийн жижүүр Э.Баттөрийн гэр бүлд хандив тусламж үзүүлсэн.

- 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр Аймгийн төрийн архивын тасгийн 2021 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 11 тоот албан бичгийн дагуу хэлтсийн 2007-2019 оны архивын баримтыг цэгцэлж, стандартын дагуу болгож Төрийн архивт байнга хадгалах 75 нэгж, түр хадгалах 406 нэгж, 70 жил хадгалах 34 нэгжийг хүлээлгэн өгсөн. 2008-2020 оны цаашид хадгалах хэрэгцээгүй болсон 191 ширхэг баримтыг устгуулах саналыг УБЕГ болон Аймгийн архивын тасагт оруулж одоогоор 162 баримтыг устгахаар болсон.

- 2021 оны 05 дугаар сарын 04-ны өдөр "ТАРЬСАН МОДОО УРГУУЛЪЯ" - Өмнөговь аймаг байгуулагдсаны 90 жилийн ойд зориулан 90 мод тарив

- 2021 оны 07 дугаар сарын 03-ны өдөр БТСГазраас зохион байгуулсан "Дасгал, хөдөлгөөн хийцгээе" аянд нэгдэж "Соёл, спортын зөвлөл" хийсэн ажлаараа 1-р байранд орсон.

- 2021 оны 07 дугаар сарын 31-ний өдөр Даланзадгад сумын ЗДТГазраас зохион байгуулсан "Шарилжгүй аянд" нэгдэж байгууллагын ойр орчмын 50 метрийн тоосонцор ургамал, шарилж, хогийг түүж цэвэрлэсэн.

АЙМАГ, ОРОН НУТГИЙН УДИРДЛАГАТАЙ ХАМТРАН АЖИЛЛАЖ, ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АЖИЛ:

• 2021 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр Улсын бүртгэлийн хэлтсийн дарга Ч.Энхмөнх Монгол Улсын Ерөнхийлөчийн сонгуулийн тухай хуулийн 25.1 дэх заалт: Иргэний шилжилт хөдөлгөөнийг сонгуулийн жилийн 2021 оны 04 дүгээр сарын 10-ний өдрөөс түр зогсоох тухай мэдээллийг орон нутгийн телевизээр дамжуулан иргэдэд мэдээлэл хүргэсэн.

➤ Шинэ төрлийн коронавирусээс урьдчилан сэргийлэх зорилгоор Төрийн байгууллагын алба хаагчдыг 24 цагийн постод гаргаж өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллаж байна. Улсын бүртгэлийн алба хаагчид 2021 оны 02 сараас 2021 оны 05 дугаар сар хүртэлх хугацаанд нийт 4 удаа Хэлтсийн бүх алба хаагчид постонд гарч дараагийн байгууллагад хүлээлгэн өгч ажилласан.

➤ ЭМЯам болон аймгийн Эрүүл мэндийн газраас цаг тухай бүр ирүүлж байгаа заавар, зөвлөмжийг тухай бүр хэрэгжүүлэн ажиллаж, ажилчид, албан хаагчид, үйлчлүүлэгчид мэдээ, мэдээлэл түгээж, ариутгах бодис, халдваргүйжүүлэлтийн арга хэмжээг шаардлага түвшинд авч ажиллаж байна.

➤ 2021.07.7, 2021.07.23-ны өдрүүдэд Аймгийн шуурхай штаб дээр Мэдээлэл технологийн ажилтан О.Эрдэнэбат, ЭХЭУБТасгийн Архивч А.Цэцэгжаргал, ИУБТасгийн улсын бүртгэгч З.Хасар, Б.Баясгалан нар шуурхай штабын утсаар иргэдэд мэдээлэл өгч ажилласан.

БОЛОВСОН ХҮЧНИЙ ТАЛААР:

Өмнөговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь Хэлтсийн дарга 1, Тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч 2, Хяналтын улсын байцаагч 1, Улсын бүртгэгч 20, Ахлах нягтлан бодогч 1, Архивч 2, Нярав, мэдээллийн технологийн ажилтан 1, Архив, бичиг хэргийн ажилтан 1, үйлчлэгч 2 /гэрээт албан хаагч/, жижүүр 2 /гэрээт албан хаагч/, нийт 33 албан хаагчтайгаар үйл ажиллагаа явуулж байна.

➤ Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2021 оны 03 дугаар сарын 01 ний өдрийн Б/01 тоот тушаалаар Булган сумын улсын бүртгэгч Б.Сайнзаяагаас ажил хүлээн авч Г.Тогтохсүрэнд Булган сумын улсын бүртгэгчийн ажлыг хүлээлгэн өгсөн.

➤ Хэлтсийн даргын 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн Б/02 тоот тушаалаар хэлтсийн жижүүр Б.Гандөшийгүүрэгт ажлаас чөлөөлсөн.

➤ Хэлтсийн даргын 2021 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн Б/03 дугаар тушаалаар Хэлтсийн гэрээт ажилтан үйлчлэгч С.Уранцэцэгийг үүрэгт ажлаас нь чөлөөлж, Т.Ариунааг Б/04 дугаар тушаалаар үйлчлэгчийн үүрэгт ажилд томилсон.

➤ Хэлтсийн даргын 2021 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн Б/05 дугаар тушаалаар Гэрээгээр хэлтсийн жижүүрийн үүрэгт ажилд Д.Цэмбэлноровыг томилсон.

➤ Хэлтсийн даргын 2021 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн Б/06 дугаар тушаалаар Гэрээт ажилтан Т.Ариунааг Хэлтсийн үйлчлэгчийн үүрэгт ажлаас чөлөөлж, 2021 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн Б/07 дугаар тушаалаар Ц.Насанбаярыг үйлчлэгчийн үүрэгт ажилд томилсон.

ТАЙЛАН МЭДЭЭ, АЛБАН БИЧГИЙН ТАЛААР:

2021 оны эхний хагас жилийн байдлаар Улсын бүртгэлийн хэлтэст 501 албан бичиг ирсэнийг зохих журмын дагуу бүртгэн авч холбогдох ажилтнуудад шилжүүлэн биелэлтэнд хяналт тавьж ажиллалаа. 404 хариутай албан бичиг ирснээс хариуг тухай бүрт нь шийдвэрлүүлэн холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн. Мөн тайлангийн хугацаанд 626 албан бичиг зохих стандарт, журмын дагуу боловсруулан холбогдох албан байгууллага, иргэдэд хүргэж ажиллаа.

Улсын бүртгэлийн хэлтэст 2021 оны эхний хагас жилийн байдлаар иргэдээс нийт 22 өргөдөл, гомдол, санал, хүсэлт ирсэнээс 21 өргөдөлийг шийдвэрлэн холбогдох албан тушаалтан, иргэдэд хариуг хүргүүлэж, 1 өргөдөл гомдол, санал хүсэлтийг холбогдох байгууллагуудад шилжүүлэн шийдвэрлэлтэнд хяналт тавьж, холбогдох газарт цаг тухай бүр хүргүүлэн ажилласан.

1. САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2. **Төсвийн зарцуулалт** : 2021 оны хагас жилийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд УБЕГазрын Санхүү, төлөвлөлтийн газарт хүргүүлэн ажилласан.

Өмнөговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн нягтлан бодогч Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг сар бүр холбогдох тодруулгын хамт Улсын бүртгэлийн ерөнхий газрын Санхүү, төлөвлөлтийн газарт хугацаанд нь хүргүүлэн ажиллана.

2021 оны хагас жилийн үйлчилгээний орлогын төлөвлөгөө 100 000 000 /Нэг зуун сая/ төгрөг. Үүнээс 2021 оны хагас жилийн байдлаар 128 668 920 /нэг зуун хорин

найман сая зургаан зуун жаран найман мянга есөн зуун хорин / төгрөг төвлөрүүлэн ажиллаж байна.

2021 оны 04 дүгээр сарын 06 -ний өдөр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Аймгийн Төрийн аудитаар шалгуулж “Зөрчилгүй” дүгнэлт авсан.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж Өмнөговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн санхүүгийн мэдээллийг сар бүрийн 8-ны өдрийн дотор 14 үзүүлэлтээр бүрэн гаргаж байршуулан, хагас жилийн тайланг илгээсэн.

3. Үйлчилгээний хураамж, үйл ажиллагааны орлого: Иргэний бүртгэлийн үйлчилгээний хураамж 210000089483 тоот дансанд, эд хөрөнгийн үйлчилгээний хураамж 210000093088 тоот дансанд, цахим үнэмлэхний үнэ 210000258471 тоот дансанд тус тус тушаалган Өмнөговь аймгийн Төрийн сангийн 100110012008 тоот дансанд төвлөрүүлэн, улмаар сар бүрийн 25-ны дотор Улсын төсөвт төвлөрүүлэн ажиллаж байна.

Бараа материал, үндсэн хөрөнгө: Иргэний бүртгэлийн 21 төрөл, Эд хөрөнгийн бүртгэлийн 3 төрөл, Хуулийн этгээдийн 3 нийт 27 төрлийн үнэт цаас ашиглагдаж байгааг УБЕГазраас хөрөнгийн санхүүжилтээр авч нөөцийг бүрэн ханган ажиллаж байна.

2. ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛ

НЭГ. БОДЛОГЫН ЗӨВЛӨГӨӨГӨӨР ХАНГАХ

Тайлангийн хугацаанд Улсын бүртгэлийн хэлтэс нь иргэний улсын бүртгэлийн чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлын талаарх тоон мэдээг сар бүр нэгтгэн гаргаж Улсын бүртгэлийн ерөнхий газрын Иргэний бүртгэлийн газарт тогтмол хүргүүлж ажиллаа.

Сумдын улсын бүртгэгч нарын сарын мэдээ, тайланг цаг хугацаанд нь үнэн зөв гаргаж байх, улсын бүртгэлийн мэдээллийн санд регистрийн дугаар буруу, овог, нэр, үсгийн зөрүүтэй иргэдийн зөрчлийг тухай бүр арилгаж дуусгах чиглэл өгч ажиллаж байна. Тухайлбал:

- ✓ 2021 оны эхний хагас жилийн байдлаар 4 иргэний регистрийн дугаарыг сольж ИУБ-25 маягтаар зөрчлийг арилгасан.
- ✓ Гэрлэлтийн бүртгэлийн мэдээлэл ороогүй 2 иргэний ИУБ-15
- ✓ Нас баралтын бүртгэлийн мэдээлэл ороогүй 2 иргэний ИУБ-18 маягтыг тус тус нөхөн бичиж мэдээллийн санд оруулсан.

- ✓ Мэдээллийн санд үсгийн алдаатай болон мэдээлэл буруу орсон 76 иргэний мэдээллийн алдааг засуулахаар тухай бүр нь Иргэний улсын бүртгэлийн газарт албан бичэг, нотлох баримтын хамт хүргүүлж зөрчлийг арилгасан.

Иргэний бүртгэлийн үйлчилгээнд гарч байгаа зөрчлийн дийлэнх нь 1988 оноос хойш төрсөн иргэдийн төрөлтийн мэдээлэлд эцэг, эхийн мэдээлэл үндсэн мэдээллийн санд тусгагдаагүй зэрэг зөрчлүүд эзэлж байна. Өмнөговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний улсын бүртгэлийн тасаг 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрөөс 2021 оны 06 дугаар сарын 25 –ны өдрийг хүртлэх хугацаанд дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

1. Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд <http://192.168.154.163/lavlagaa/> танилцуулж мөн “SPARK” мессэж үйлчилгээг 13 сумын болон иргэний улсын бүртгэлийн улсын бүртгэгч нарт ашиглаж эхэлсэн
2. Улсын бүртгэлийн ерөнхий газрын Бодлого төлөвлөлт, дүн шинжилгээний газраас 2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр зохион байгуулсан “Байгууллагын болон төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах арга зүй” сэдэвт онлайн сургалтанд хамрагдсан.
3. Улсын бүртгэлийн нэгдсэн архивын 2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 11/622 тоот албан бичгийн дагуу устгах баримт бичгийн жагсаалтаар ирсэн зөвшөөрлийн дагуу ББНШКомиссын хурлаар оруулж устгах баримтыг ангилан ялгасан.
4. Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын баталсан “Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулиар улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэх үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөө”-ний 20 дугаар заалт, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дэд даргын 2021 оны 02 дугаар сарын 01-ны өдрийн 2/699 тоот чиглэлийн 5 дугаар заалтын дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Өмнөговь аймгийн 15 сумын сонгуулийн хэсэг байгуулж, нутаг дэвсгэрийг зарласан, тогтоолын эх хувийг 2021 оны 02 дугаар сарын 23 өдрийн 2/204 тоот албан бичгээр Иргэний улсын бүртгэлийн газарт хүргүүлсэн.
5. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Өмнөговь аймгийн 15 сумын сонгуулийн хэсэг байгуулж, нутаг

дэвсгэрийг зарласан, тогтоолыг <http://election.gasr.mn>-д шивж оруулан, 61 хэсгийн санал авах байрны мэдээллийг оруулж баталгаажуулсан.

6. Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2021 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн “Иргэний шилжилт хөдөлгөөнийг түр зогсоох тухай” А/59 дүгээр тушаалыг нийт бүртгэгч нарт танилцуулж, хэрэгжилтийг хангаж ажилласан.
7. Хэлтсийн ББНШКомиссын хурлаар оруулсан устгах баримтын жагсаалтын дагуу бүртгэлийн журнал 280 ширхэг, ИУБ-21 маягт 7308 ширхэг, ИУБ-22 маягт 11631 ширхэг, СНЖагсаалт 1006 , сонгуулийн бүртгэлийн хуудас 164767 ширхэг тус бүрийг устгасан.
8. Өмнөговь аймгийн Гашуун сухайт, Шивээ хүрэн боомтуудад үйл ажиллагаа явуулж ХХК болон хувиараа нүүрс тээвэрлэлт явуулж буй нийт 240 жолооч нарын үндэсний энгийн гадаад паспортын зөрчилтэй болон хугацаа дууссан паспортын захиалгыг иргэдээс авч иргэний бүртгэлийн мэдээллийн санд бүртгэлийг хийж 2021 оны 2 дугаар сарын 3-ны өдрийн 2/136 тоот албан бичгээр Иргэний бүртгэлийн газарт хүргүүлэн 2021 оны 2 дугаар сарын 6-ны өдөр Гашуун сухайт, Шивээ хүрэн боомтуудад захиалга өгсөн иргэдэд олголт хийсэн.
9. Өмнөговь аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн А/180 тоот захирамжаар Ханбогд сумын Хайрхан багийн Цагаанхадны суурьшлын бүсийн иргэдэд түр үнэмлэх олгох ажлын хэсэгт Улсын ахлах бүртгэгч Б. Должинсүрэн 2021 оны 02 дугаар сарын 18-наас 2021 оны 02 дугаар сарын 20-ны өдрүүдэд ажилласан.
10. 2021 оны 02 дугаар сарын 03-ны өдөр аймгийн ЗДТГазарт Өмнөговь аймгийн харьяат 85 наснаас дээш насны 357 иргэний судалгааг гарган хүргүүлсэн.
11. 15 сумын улсын бүртгэгчийн иргэний бүртгэлийн бүрдүүлбэр нотлох баримт бичгийг Хяналтын улсын байцаагч Д. Наранбилэг, Улсын ахлах бүртгэгч Б. Должинсүрэн нар шалгасан.
12. 2021 оны 3 дугаар сарын 4-ны өдөр "Төрийн алба дахь эмэгтэйчүүдийн манлайлал" онлайн сургалтанд хамрагдсан.
13. Өмнөговь аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн А/180 тоот захирамжаар Ханбогд сумын Хайрхан багийн Цагаанхадны суурьшлын бүсийн иргэдэд түр үнэмлэх олгох ажлын хэсэгт Улсын ахлах

бүртгэгч Б. Должинсүрэн 2021 оны 03 дугаар сарын 15-наас 2021 оны 03 дугаар сарын 17-ны өдрүүдэд ажилласан.

14. 2021 оны 4 дүгээр сарын 16-ны өдөр Өмнөговь аймгийн 15 сумын сонгуулийн 61 хэсгийн хорооны санал авах байрны дэргэд ажиллах бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтны судалгааг УБЕГазарт болон аймгийн Тагнуулын газарт хүргүүлсэн.
15. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд burtgel.gov.mn хаягт байршуулсан СНЖагсаалтанд Өмнөговь аймгийн харъяат 7 иргэний алдаатай мэдээллийг арилгасан тухай илтгэх хуудсыг 2021 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр МТГазарт хүргүүлсэн.
16. 2021 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр "E-mongolia" онлайн захиалга нэгдсэн системд ажиллах сэдэвт ИУБГазар, МТГазраас зохион байгуулсан онлайн сургалтанд хамрагдсан
17. 2021 оны 4 дүгээр сарын 2-ны өдөр Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан "Төрийн албан дахь бодлогын инновац" сэдэвт онлайн сургалтанд хамрагдсан.
18. 2021 оны 4 дүгээр сарын 8-ны өдөр Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан "E-Mongolia цахим үйлчилгээний систем" сэдэвт онлайн сургалтанд хамрагдсан.
19. Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2021 оны 04 дүгээр сарын 27-ний өдрийн 5/2985 тоот чиглэлийн дагуу авч хэрэгжүүлсэн ажлын тайланг 2021 оны 5 дугаар сарын 08-ны өдөр хүргүүлсэн.
20. Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын баталсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд зохион байгуулах чиглэл өгөх цахим сургалтын хөтөлбөрийн хүрээнд Өмнөговь аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс нь 2021 оны 05 дугаар сарын 12-ны өдөр 61 хэсэгт ажиллах 61 итгэмжлэгдсэн ажилтан, 13 нөөцийн ажилтан, нийт 74 итгэмжлэгдсэн ажилтанд хууль эрх зүйн сургалтыг танхимаар болон цахимаар зохион байгуулсан.
21. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 19 дүгээр зүйл, 19.9 дэх хэсэгт заасны дагуу 2021 оны 5 дугаар сарын 13-ны өдөр Өмнөговь аймгийн 61 хэсгийн хорооны сонгогчдын нэрийн жагсаалт хэвлэх, 2021 оны 5 дугаар сарын 13,14,15-ны өдрүүдэд СНЖагсаалтыг сонгуулийн хэсгийн

хороодод хүргэх ажлыг зохион байгуулж сургалтын тайланг 2021 оны 05 дугаар сарын 17-ны өдөр ИУБГазарт хүргүүлсэн.

22. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Өмнөговь аймгийн 61 хэсгийн хорооны сонгогчдын нэрийн жагсаалтанд өөрчлөлт оруулах тухай лавлагааг 2021 оны 05 дугаар сарын 25, 26-ны өдөр Иргэний улсын бүртгэлийн систем election.gasr.mn хаягаас хэвлэсэн илтгэх хуудас хүргүүлсэн.
23. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд burtgel.gov.mn хаягт байршуулсан СНЖагсаалтанд Өмнөговь аймгийн харъяат 25 иргэний алдаатай мэдээллийг арилгасан тухай илтгэх хуудсыг 2021 оны 4 дүгээр сарын 29, 2021 оны 5 дугаар сарын 6,13,20-ны өдөр Хамтын ажиллагаа, сургалтын хэлтэст хүргүүлсэн.
24. 2021 оны 5 дугаар сарын 10-ны өдөр УБЕГазраас зохион байгуулсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд зохион байгуулах чиглэл өгөх цахим сургалтанд хамрагдсан.
25. 2021 оны 5 дугаар сарын 20-ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Өмнөговь аймгийн 61 хэсгийн хороонд хэрэглэх бүртгэлийн тоног төхөөрөмжийг хүлээн авч аймгийн Тагнуулын газар байрлуулсан.
26. Өмнөговь аймгийн хэмжээнд нийт 517 лавлагаа хэвлэгдсэнээс шилжин ирсэн сонгогч 309, шилжин явсан сонгогч 186, иргэний улсын бүртгэлтэй холбоотой өөрчлөлтийн, нас барсны бүртгэлийн 21 лавлагааг тус тус хэвлэн Монгол улсын ерөнхийлөгчийн сонгуулийн сонгогчдын нэрийн жагсаалтанд өөрчлөлт оруулах тухай лавлагаа хэвлэсэн илтгэх хуудсыг 2021.05.26-ны өдөр ИУБГазарт хүргүүлсэн.
27. УБЕГазрын сургалтын баг, Өмнөговь аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс 2021 оны 06 дугаар сарын 1-ний өдөр 61 хэсэгт ажиллах 61 Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтнуудад зохион байгуулсан сонгогчдын ирц бүртгэлийн програмын сургалтын тайланг ИУБГазарт хүргүүлсэн.
28. 2021.06.25-ны өдөр Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд зохион байгуулах сургалтанд ИУБТасаг хамрагдсан.

29.2021.06.22-ны өдөр Иргэний улсын бүртгэлийн системийг танилцуулах, сургах сургалтанд 16 сумын бүртгэгч болон ИУБТасаг бүрэн хамрагдсан.

30.2021.06.09-ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн өдөр Өмнөговь аймгийн хэмжээнд 24116 сонгогчид бүртгэлийн хуудас олгон 52.66 хувийн ирцтэй дууссан.

Иргэний улсын бүртгэлийн үйл ажиллагааг иргэдэд сурталчилах, ил тод нээлттэй байдлыг хангах зорилгоор хэлтсийн мэдээллийн самбарт иргэний гэр бүлийн бүртгэлийн талаарх мэдээллийг сар бүр шинэчилж байршуулж, хэлтсийн вэб www.ubh.om.gov.mn сайтад сар бүрийн бүртгэлийн тоон мэдээллийг графикаар тухай бүр оруулсан.

ХОЁР. ИРГЭНИЙ ГЭР БҮЛИЙН БҮРТГЭЛ, ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙ ТАЛААР

Иргэний улсын бүртгэлийн үйл ажиллагааг явуулахдаа гэр бүлийн тухай болон иргэний улсын бүртгэлийн тухай хууль бусад хууль эрх зүйн баримт бичгүүдийг мөрдлөг болгон хэрэгжүүлж ажиллаа. Иргэний бүртгэлийн мэдээллийн санд дараах бүртгэлүүдийг баталгаажуулсан.

Үүнд :

1. Төрсний – 1040
2. Үрчилсний –8
3. Овог, нэр өөрчилсний –23
4. Эцэг тогтоосны–12
5. Гэрлэсний – 143
6. Гэрлэлт дуусгавар болсны – 38
7. Нас барсны -181
8. Аймаг дотрох шилжилт хөдөлгөөн –990
9. Бусад аймаг хотоос шилжин ирсэн – 412 тус тус бүртгэгдсэн байна.

10.2020 оны эхний хагас жилд бүртгэгдсэн иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийг 2021 оны эхний хагас жилд бүртгэсэн бүртгэлтэй харьцуулсан үзүүлэлт

Он	Төрсний	Гэрлэсний	Гэрлэлт дуусгавар болсны	Үрчилсний	Овог нэр өөрчилсний	Эцэг тогтоосны	Гэрлэлт сэргээсний	Нас барсны
----	---------	-----------	--------------------------	-----------	---------------------	----------------	--------------------	------------

2020 оны эхний хагас жил	919	176	40	13	50	34		170
2021 оны эхний хагас жил	1040	143	38	8	23	12		181
Өсөлт бууралт	121	-33	-2	-5	-27	-22		11

11.

12.2020 оны эхний хагас жилд бүртгэгдсэн шилжилт хөдөлгөөний бүртгэлийг

13.2021 оны эхний хагас жилд бүртгэгдсэнтэй харьцуулсан үзүүлэлт

Он	Бусад аймаг хотоос шилжин ирсэн	Аймаг дотор шилжин ирсэн
2020 оны эхний хагас жил	357	824
2021 оны эхний хагас жил	412	990
Өсөлт бууралт	55	146

14.

15. ГУРАВ. ҮНДЭСНИЙ ЭНГИЙН ГАДААД ПАСПОРТ ОЛГОЛТЫН ТАЛААР

16.2021 оны эхний хагас жилд 432 иргэнд шинээр гадаад паспорт олгох хүслэтийн хүлээн авч гадаадад зорчих эрхийн бүртгэлд бүртгэсэн.

17.2020 оны 1-р улиралд гадаад паспорт, хил орчмын нэг болон олон удаагийн үнэмлэх олголтын байдлыг 2021 оны 1-р улирлын олголтын байдалтай харьцуулсан үзүүлэлт

Он	Гадаад паспорт шинээр	Хил зорчих олон удаагийн үнэмлэх	Хил зорчих нэг удаагийн үнэмлэх
2020 оны эхний хагас жил	324	32	2
2021 оны эхний хагас жил	432		
Өсөлт бууралт	108	-32	-2

18. ДӨРӨВ. ИРГЭНИЙ ҮНЭМЛЭХ ОЛГОЛТ, АРХИВЫН САНГИЙН

19.ХӨДӨЛГӨӨНИЙ ТАЛААР

20.2021 оны эхний хагас жилийн байдлаар нийт 1745 иргэний цахим үнэмлэх хүлээн авч иргэдийн гар дээр нийт 1600 иргэний цахим үнэмлэх олгогдоод байна.

- 21.Онлайн бүртгэлийн санд 11 бүртгэл ХААТР-11, ХААТР-15, ХААТР-18 маягтыг нөхөн мэдээллийн санд тусгасан. Регистрийн дугаарыг сар, өдрийг зөрүүлж олгосон 4 иргэний эмнэлгийн байгууллагын тодорхойлолт, холбогдох бичиг баримтыг үндэслэн ХААТР-25 маягт бичиж мэдээллийг засварлаж зөрчлийг арилгасан.
22. Архивийн сангаас 112 иргэний хувийн хэрэг татан авч шалгаснаас зөрчилтэй иргэний мэдээллийг цаг тухайд нь Иргэний бүртгэлийн газарт албан тоот хүргүүлж зөрчлийг арилган буцаан байрлуулсан байна

23. ТАВ. АРХИВААС ЛАВЛАГАА ОЛГОЛТ

- 24.Иргэний улсын бүртгэлийн архивын сангийн баяжилтанд орсон ИУБ маягтын тоон мэдээллийг сар бүр тогтмол гарган иргэний баримтын төв архивт хүргүүлсэн.
- 25.Иргэн , албан байгууллага, хууль хяналтын байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу 2655 лавлагаа гаргаснаас иргэнд 2201, албан байгууллагад 130 тус тус олгосон байна.
- 26.ИУБ-11 1040, ИУБ-12 8, ИУБ-13 23, ИУБ-14 12, ИУБ-15 143, ИУБ-16 38, ИУБ-18 181, ИУБ-22 1402, ИУБ-31 1745, ИУБ-21 1600, нийт 6192 маягт архивт байрлуулж, архивийн баяжилтыг цаг тухайд нь бүрэн хийж ажилласан.
27. Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр давхардсан тоогоор 8500 иргэнд улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлсэн байна.

3. ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛ

Нэг. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагааны бодлого төлөвлөлтийн хүрээнд

2021 оны 2 дугаар улиралд эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн үйл ажиллагаандаа Монгол улсын “Иргэний хууль”, “Улсын бүртгэлийн ерөнхий хууль”, “Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль”, “Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль” болон холбогдох бусад хууль, Улсын бүртгэлийн ерөнхий газраас гаргасан шинээр мөрдөгдөж байгаа дүрэм, журмыг мөрдлөг болгон газар, хэлтсийн даргаас өгсөн удирдамж чиглэлийн дагуу ажиллалаа.

2021.01.18-ны өдөр аймгийн аймгийн ГХБХБ-ын газрын удирдлага, мэргэжилтэнүүдтэй шинээр мөрдөж буй хаягийн тогтоолыг хэрхэн хэрэгжүүлэх, сумдын газрын даамлуудаас ирүүлж байгаа газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн нотлох баримтад анхаарах асуудлын талаар уулзалт зохион байгуулсан.

Улсын бүртгэлийн Ерөнхий хуулийн 9.11-д заасан дундын мэдээллийн санд Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тухай хуулийн 28 дахь хэсэгт заасан нотлох

баримтыг үндэслэн иргэн хуулийн этгээдийн газар эзэмшиж, ашиглах эрхийн нийт **939** хүсэлтийг баталгаажуулж А, Э дугаар олгосон.

2021.03 дугаар сард УБЕГ-ын ЭХЭУБ-н газраас ирүүлсэн чиглэлийн дагуу архивын цаасан суурьт нотлох баримтын тооллого зохион байгуулж алгасаж олгосон УБ-ын дугаарын судалгааг гаргаж ЭХЭУБ-ын газарт хүргүүлсэн.

2021.03.15-18-ны өдрүүдэд аймгийн ГХБХБГазар, Ханбогд сумын ЗДТГазартай хамтарсан ажлын хэсэг байгуулж Ханбогд сумын иргэдэд өмчлүүсэн газрын хаяг давхардаж улсын бүртгэлд бүртгүүлсэн иргэдийн хүсэлтийг хүлээн авч сумын засаг даргын А/88, А/86 тоот захирамж, холбогдох бусад нотлох баримтыг үндэслэн **22** иргэний өмчлөлийн газрын хаяг залруулан газар дээр нь шийдвэрлэсэн.

2021.05.11-ны өдөр аймгийн ГХБХБГазарт хүсэлт хүргүүлэн Барилга хот байгуулалтын сайдын 2018.12.31-ны өдрийн 218 тоот тушаалаар батлагдсан “Барилга байгууламжийн төвөгшлийн ангилалыг зориулалт, хүчин чадлаар нь тогтоох дүрэм”-ын хэрэгжүүлэхэд тулгамдаж байгаа асуудлаар хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулсан.

2020 оны нэгдүгээр улирлын байдлаар **2000** гаруй иргэн, хуулийн этгээдэд эд хөрөнгө өмчлөх, эзэмших, ашиглах эрх түүнтэй холбоотой бусад эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлж, мэдээлэл зөвлөгөө өгч ажиллалаа.

Сумдын улсын бүртгэгч нарт ЭХЭУБ-ийн талаар зөвлөмж чиглэл өгч газрын анхны бүртгэлийн **94** мэдүүлэг, газраас бусад үл хөдлөх хөрөнгө бүртгүүлэх **20** мэдүүлэг улсын бүртгэгч нараас хүлээн авч бүртгэн 92 гэрчилгээг буцааж хүргүүлэн иргэдийн гарт хүргэсэн.

УБЕГгазаас зохион байгуулсан онлайн сургалтанд **4** удаа хамрагдаж өгсөн чиглэл зөвлөмжийг өдөр тутмын ажил үйлчилгээнд мөрдөн ажиллаж байна.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн сарын мэдээг Улсын бүртгэлийн ерөнхий газрын Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газарт хуулийн хугацаанд хүргүүлэн газар, хэлтсийн дарга, холбогдох албан тушаалтнуудыг эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн холбогдох мэдээ, мэдээллээр хангаж ажилласан.

Хоёр. Эд хөрөнгө өмчлөх, эзэмших, ашиглах эрхийг бүртгэж баталгаажуулах

2021 оны хагас жилд иргэн, хуулийн этгээдээс үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой бүртгэлийн мэдүүлэг **2024**, газар өмчлөх эрхтэй холбоотой бүртгэлийн мэдүүлэг **2353** нийт **4377** мэдүүлэг хүлээн авч хянан, холбогдох хууль тогтоомжийн дагуу эд хөрөнгө өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлсэн байна. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагааг хуульд нийцүүлэн хөнгөн шуурхай явуулах эрх зүйн орчинг бүрдүүлэхэд шаардлагатай журам, заавар, зөвлөмж болон “Улсын бүртгэлийн ерөнхий хууль”, “Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль” болон эрхийн улсын Ерөнхий бүртгэгчийн тушаалаар батлагдсан дүрэм, журмыг мөрдөн ажиллаж байна.

Эд хөрөнгө өмчлөх эрхийн анхны бүртгэлд 622 иргэний өмчлөх эрхийг баталгаажуулсанаас : Төрөөс үнэгүй хувьчилсан газар өмчлөх эрхийн бүртгэл 365, Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн бүртгэл 181, шинээр баригдсан орон сууцны анхны бүртгэлд 70, төрөөс хувьчилсан орон сууцны өмчлөх эрхийг анх удаа бүртгүүлэх 6 хүсэлт хүлээн авч бүртгэсэн.

Гэрээ хэлцэл нийт 3291 бүртгэгдсэнээс: Худалдах, худалдан авах гэрээ 546, Бэлэглэх гэрээ 82, Арилжих гэрээ 7, Хамтран өмчлөгч өөрчлөгдөх 28, гэрээслэлээр болон өв залгамжлах эрхийн бүртгэл 25, Шүүхийн шийдвэрээр өмчлөгч өөрчлөгдөх бүртгэл 5, Барьцааны гэрээтэй холбоотой бүртгэл 2598 тус тус бүртгэсэн.

Эрхийн улсын бүртгэлд өөрчлөлт залруулгаар 174 бүртгэл бүртгэсэнээс:

Эд хөрөнгийн хаяг, хэмжээ, үнэ, гүйцэтгэл өөрчлөгдөх 149, Эд хөрөнгийн зориулалт өөрчлөгдөх, залруулга 8, үрэгдүүлсэн болон гэмтээсэн гэрчилгээ дахин олгох бүртгэл 12, хувийн хэрэг хаах бүртгэл 5 тус тус бүртгэсэн байна.

Гурав. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн талаарх мэдээллийн сан болон нотлох баримтаар хувийн хэрэг бүрдүүлж, иргэн, хуулийн этгээд болон хууль хяналтын байгууллагыг лавлагаа, мэдээллээр хангах

Шүүх, Цагдаа, Прокурор, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба болон бусад байгууллагад албан бичгээр эд хөрөнгө өмчлөх эрхтэй холбоотой 127 лавлагаа олгосон. Байгууллагыг төлөөлж эд хөрөнгийн маргаантай бүртгэлээр шүүх хуралд оролцоогүй. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн талаар иргэн, хуулийн этгээдэд 163 лавлагаа олгосон.

Иргэн хуулийн этгээдээс хүлээн авсан эх нотлох баримтуудаар хувийн хэрэг үүсгэж газар өмчлөх эрхийн 15139 хувийн хэрэг, газраас бусад үл хөдлөх хөрөнгийн 8309 хувийн хэрэг, газар эзэмших эрхийн 2407 хувийн хэрэг, газар ашиглах эрхийн 51 хувийн хэрэг нийт **25906** хувийн хэрэг цаасан хэлбэрээр архивт хадгалдагдаж байна.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээний хураамжаар нийт **70,370,846** төгрөгийг улсын төсөвт, тэмдэгтийн хураамжаар **2676784** төгрөг, үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсаны орлого **121,519,076** төгрөгийг орон нутгийн төсөвт тус тус төвлөрүүлэн ажиллалаа.

4.ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН БҮРТГЭЛ

Тайлангийн хугацаанд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн ажил, үйлчилгээг Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Иргэний хууль, Компанийн тухай хууль болон холбогдох бусад хууль, дүрэм, журам, удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, чиглэлийг бүрэн хэрэгжүүлж, 2021 оны эхний

хагас жилийн байдлаарнийт 2200 иргэн, хуулийн этгээдэд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлсэн. Үүнд:

- ✓ Хуулийн этгээд нэрийн баталгаажуулалт - 238
- ✓ Шинээр үүсгэн байгуулсан хуулийн этгээд - 198
 - Хязгаарлагдмал хариуцлагатай компани –183
 - Төрийн бус байгууллага /НҮТББ, ГҮТББ/ – 12
 - Нөхөрлөл - 3

Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлт -1027

- ✓ Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ дахин олгосон – 84
- ✓ Хуулийн этгээдийн бүртгэлийн лавлагаа олгосон -146
 - Цахим сүлжээнээс -130
 - Архивын хуулбар - 16
- ✓ Хуулийн этгээд татан буулгасан бүртгэл – 1тус тус бүртгэсэн.
- ✓ Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 8.3 т заасаны дагуу Өмнөговь аймагт үйл ажиллагаа явуулах 15 хуулийн этгээдийн салбарыг бүртгэсэн.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны а/216 тоот тушаалаар батлагдсан “Тамга, тэмдэг хийлгэх үйл ажиллагаанд хяналт тавих, лавлагаа олгох журам”-ын дагуу Хуулийн этгээдийн тамга, тэмдэгийн хяналтын хуудас 223 олгож, хуулийн этгээдийн 23 тамга, тэмдгийг хураан авч хүчингүй болгосон.

Тайлангийн хугацаанд шинээр байгуулагдсан 198 хуулийн этгээдийн, 1111 хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийн, лавлагааны эх нотлох баримт бичиг хураан авсан тамга тэмдгийг тус тус дүрэм журмын дагуу архивт хүлээлгэн өгч, цаасан баримтыг цахим хэлбэрт шилжүүлэн ажиллаж байна.

2020 оны энхий хагас жилд байдлаар хуулийн этгээдийн бүртгэлийн бүх төрлийн үйчилгээний хураамж **22719000** төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн.

Хуулийн этгээдийн бүртгэлийн хөдөлгөөний тоон мэдээ, архивын мэдээ, үнэт цаасны мэдээ, үйлчилгээний орлогын мэдээг сар бүрийн 25 ны өдрөөр гаргаж УБЕГазрын хуулийн этгээдийн газар, архивын газар, хэлтсийн нягтлан бодогчид тус тус хүргүүлэн ажиллаж байна.

Тайлангийн хугацаанд дараах ажил, үйлчилгээг гүйцэтгэсэн. Үүнд:

- 2021 оны 01 дүгээр сарын 05 нд Улсын бүртгэлийн хэлтсээс зохион байгуулсан сумын улсын бүртгэгч нарт зориулсан цахим сургалтанд оролцож, хуулийн этгээдийн бүтгэлийн талаар мэдээлэл хүргэсэн.
- 2021 оны 01 дүгээр сарын 22 нд УБЕГазраас зохион байгуулсан “Төрийн албан хаагчийн гүйцэгэлийн төлөвлөгөө боловсруулах, үнэлэх аргачлал” сэдэвт online сургалтанд хамрагдсан.
- 2021 оны 04 дүгээр сарын 08 нд Өмнөговь аймаг дахь Төрийн албаны салбар зөвлөлөөс зохион байгуулсан “E-Mongolia цахим үйлчилгээний систем”-ийн талаарх цахим сургалтанд хамрагдсан.
- 2021 оны 04 дүгээр сарын 08 нд УБЕГазрын Хяналт шалгалтын газраас зохион байгуулсан “Эрхийн улсын бүртгэлд урьдчилсан тэмдэглэл хийх хүчингүй болгох, ХЭУБүртгэлд хориг тавих цуцлах бүртгэлд анхаарах асуудлууд” сэдэвт цахим сургалтанд хамрагдсан.
- 2021 оны 05 дугаар сарын 10 нд УБЕГазраас зохион байгуулсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн талаарх цахим сургалтанд хамрагдсан.
- 2021 оны 05 дугаар сарын 10 нд Өмнөговь аймгийн Татварын хэлтэсээс “Татвар төлөгчдийн өдрийг тохиолдуулан” зохион байгуулсан цахим сургалтанд оролцож хуулийн этгээтэй холбоотой Зөрчлийн тухай хуулиар мэдээлэл хүргэв.
- 2021 оны 05 дугаар сарын 12 нд УБЕГазраас зохион байгуулсан “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуул”-ийн эрх зүйн цахим сургалтанд хамрагдсан.
- 2021 оны 06 дугаар сарын 01 нд Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн 14 дүгээр тойргийн 61 хэсгийн хорооны санал авах байрны дэргэд ажиллах Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтануудад зориулсан эрх зүйн болон програмын 2 өдрийн сургалтанд бүрэн хамрагдсан.
- 2021 оны 06 дугаар сарын 09 нд Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн 14-р тойргийн 1-8 дугаар хэсгийн хороонд Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажилласан.
- Баяндалай, Булган, Номгон, Ханхонгор сумын улсын бүртгэгчээр шинээр томилогдсон улсын бүртгэгч нарыг хуулийн этгээдийн улсын бүртгэлд дадлагажуулан ажилласан.
- “Монгол бичиг үндэсний хөтөлбөр 3” хөтөлбөрийн хүрээнд хэлтэсээс долоо хоног өдрийн лхагва гаригт зохион байгуулагддаг монгол бичгийн чадвар нэмэгдүүлэх онлайн болон танхимын сургалтанд бүрэн хамрагдсан.

5. ПРОГРАМ ХАНГАМЖИЙН ТАЛААР

Өмнөговь аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээллийн технологийн ажилтан нь “Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам”, монгол улсын засгийн газраас баталсан “Мэдээлэл, сүлжээний аюулгүй байдлыг хангах” журмыг удирдлага болгон дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Мэдээлэл технологийн чиглэлээр

Мэдээлэл технологийн чиглэлээр 2021 оны эхний хагас жилд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

Иргэдэд үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалт болон шинэчлэгдсэн баримт бичгүүдийг цахимд ойлгогдохуйц байдлаар байршуулсан.

Цахим хуудаст байгууллагын үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй мэдээллийг цаг тухай бүрт нь байршуулсан ба эхний хагас жилийн байдлаар цаг үе, үйл явдлын талаарх мэдээ 20, иргэд, аж ахуй нэгжүүдэд заавар зөвлөгөө өгсөн талаар бичлэг 8, иргэд аж ахуй нэгжүүдэд заавар зөвлөгөө өгсөн мэдээлэл 30-г байгууллагын албан ёсны цахим хуудас болох www.umnugovi.burtgel.gob.mn хаяг болон [Өмнөговь аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс facebook page-д](#) байршуулан ажиллаж байна.

Ажлын сул орон тооны зарыг цахим хуудсанд байршуулан зарын групп хуудсанд нийтлэн олон нийтэд нээлттэй зарлан ажилласан.

Баяндалай сумын улсын бүртгэгчийн онлайн сүлжээ холбосон кабелийн утас гадны шалтгааны улмаас тасарсныг шинээр шилэн кабель татаж, шуурхай арга хэмжээ аван шаардлагатай тоног төхөөрөмжүүдтэй холбож хэвийн ажиллагаанд оруулсан.

Байгууллагын ашиглах хугацаа дууссан эд хөрөнгө, компьютер болон бусад тоног төхөөрөмжүүдийг актлах санал гаргаж Улсын бүртгэлийн ерөнхий газарт хүргүүлсэн.

Улсын бүртгэлийн ерөнхий газраас хүргүүлсэн зөвлөмжийн дагуу цахим хуудсын ажиллагааг тогтворжуулж цаг үе, үйл явдлын мэдээг тухай бүрт нь байршуулж иргэдэд мэдээ, мэдээллийг цаг алдалгүй хүргэх ажлыг хийж гүйцэтгэж байна.

Хэлтсийн албан хаагчдын компьютер, тоног төхөөрөмжүүдийг эвдрэл гэмтэл гарсан үед цаг алдалгүй тухай бүрт нь засварлаж хэвийн ажиллагаанд ажиллуулж байна.

Байгууллагын дотоод сүлжээний ажиллах хэвийн байдлыг бүрдүүлэн сүлжээнд алдаа гарах, тасрах гэх мэт техникийн саатлуудыг тухай бүрт нь холбогдох арга хэмжээг аван ажиллаж байна.

2021 оны эхний хагас жилд Улсын бүртгэлийн ерөнхий газраас цахим видео хурал, болон сургалтууд 10 гаруй удаа хийгдэж цахим хурлыг тухай бүрт нь холбон техник төхөөрөмжийг хэвийн ажиллуулсан байна. Өмнөговь аймаг дахь Улсын

бүртгэлийн хэлтэс нь сумын улсын бүртгэгч нартайгаа цахим видео хурал болон сургалтыг 4 удаа амжилттай холбон ажилласан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийн итгэмжлэгдсэн ажилчдад зориулсан хууль эрх зүй, арга зүйн сургалтыг цахим видео хэлбэрээр холбон ажилласан. Мөн “Ирц бүртгэлийн программын сургалт”-нд итгэмжлэгдсэн ажилчдад арга зүйн болон программын заавар зөвлөгөөг өгөн ажилласан.

Байгууллагын сүлжээний аюулгүй байдал, гадны халдлага, мэдээлэл алдагдхаас сэргийлэн арга хэмжээ авч ажиллан Улсын бүртгэлийн ерөнхий газраас өгсөн заавар зөвлөмжийн дагуу сүлжээний хамгаалалтыг сайжруулж тохиргоог хийн ажиллаж байна.

Ил тод байдлын чиглэлээр

Байгууллагын хийж гүйцэтгэсэн ажил, иргэдэд мэдээллэх шаардлагатай мэдээг цаг тухай бүрт нь байршуулсан ба 10 мэдээ мэдээллийг самбарт хэвлэн байршуулсан байна.

Байгууллагын хийж гүйцэтгэсэн ажил, иргэдэд мэдээллэх шаардлагатай мэдээг цаг тухай бүрт нь байршуулсан ба цахим хуудас болон [facebook](#) хуудсанд 58 мэдээ тухай бүр тавигдсан байна.

Өргөдөл, гомдол хүлээн авах хариуцсан албан хаагчийн албан тушаал, овог нэр, харилцах утасны дугаар тодорхой бичиж цахимд байршуулсан.

Сул орон тооны зарыг нийтэд зарлах, цахим болон мэдээллийн самбарт иргэдэд харагдахуйц байршуулсан ба нийт 1 сул орон тооны зарыг байршуулан ажиллаж байна.

COVID-19 вирус дэлхий даяар тархсантай холбоотойгоор байгууллагын цахим хуудсаар мэдээ мэдээлэл 7, заавар зөвлөмж 12 (үүнээс бичлэгээр 4) дамжуулан иргэдэд хүргэсэн байна.

Бусад ажлын чиглэлээр

Байгууллагын эвдэрч засах шаардлагатай эд зүйлсийг тухай бүрт засаж янзалж хэвийн болгон янзалсан. Байгууллагын серверийн өрөөн доторх эд зүйлийг цэгцэлж хэрэггүй ашиглагдах боложгүй болсон эд зүйлсийг устгалд оруулсан.

Байгууллагаас зохион байгуулж байгаа хамт олны ажилд идэвх санаачлагатай оролцон ажиллаж байна.

Няравын ажил үүргийг давхар эрхэлж байгаа тул сар бүрийн үнэт цаасны мэдээг нэгтгэх, шаардлагатай үнэт цаасыг захиалах, бичиг хэргийн холбогдолтой зүйлсийг цуглуулах, зөв хувиарлах ажлуудыг хийж байна.

Мөн удирдлагаас өгсөн үүрэг даалгаварыг цаг тухай бүрт нь хийж гүйцэтгэж байна.

6. УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ ТАЛААР

Хяналтын улсын байцаагчаас Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний улсын бүртгэлийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх журам болон бусад холбогдох хууль тогтоомж, журмыг сурталчилан, хэрэгжилтэд хяналт тавин ажиллалаа. Мөн хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг улирал, хагас, бүтэн жилээр гарган хэлтсийн даргаар баталгаажуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна

Байнгын хяналтыг иргэний улсын бүртгэл, хуулийн этгээдийн бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, архив, мэдээллийн технологийн аюулгүй байдлын чиглэлээр хийсэн.

ИУБүртгэл: Зөрчлийн тухай хуулийн 15.24.1, 15.24.2, 15.24.4, 10.20.1 дүгээр зүйлийн дагуу зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагааг нийт 389 иргэн, хуулийн этгээдэд нийт 13 065 000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн. Үүнээс:

- Иргэний үнэмлэх сунгалтын хугацаа хэтрүүлсэн 235 иргэнийг 4 700 000 төгрөгөөр,
- Иргэний цахим үнэмлэх үрэгдүүлсэн 143 иргэнийг 4 290 000 төгрөг,
- Иргэний цахим үнэмлэх гэмтээсэн 3 иргэнийг 75 000 төгрөг
- Хуулийн этгээдийн тамга тэмдэгээ үрэгдүүлсэн 4 компанийг 2 000 000 төгрөгөөр, хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтөө хуулийн хунацаанд бүртгүүлээгүй 4 компанийг 2 000 000 төгрөгөөр тус тус торгож, тухай бүрт нь аймгийн Хяналтын прокурор Г.Ганбаярт хянуулж холбогдох зөвлөгөө мэдээллийг авч, хамтран ажилласан. Мөн шийтгэлийн хуудасны зарцуулалтын тайланг сар бүр гаргаж ахлах нягтлан бодогчид хүлээлгэн өгсөн.
- Иргэний баримт бичгийн зөрчлөө арилгуулах өргөдөл гаргасан 20 иргэний дүгнэлтийг Хяналт, шалгалтын газарт хүргүүлж, online програмд баталгаажиж бүрэн шийдвэрлэсэн. Хяналтын улсын байцаагчийн хяналт, шалгалтын төлөвлөгөөний дагуу хөдөөгийн 7 сумын 2020 онд бүртгэсэн иргэний гэр бүлийн байдлын 8 төрлийн бүртгэлийн нийт 3040 материалд хяналт, шалгалт хийхэд ноцтой зөрчил дутагдал илрээгүй бөгөөд иргэний цахим үнэмлэхний хүчинтэй хугацааг нягтлан шалгах, өргөдлийн огноо, толгойг зөв бичүүлж байх, хураан авч, хувийн хэргийн эх нотлох баримтанд хавсаргасан гэрчилгээг хүчингүй болгож байх тал дээр нийт бүртгэгч нарт 2021 оны 03 дугаар сарын 29-нд зөвлөмж хүргүүлсэн. Тайлант хугацаанд шилжилт хөдөлгөөний бүртгэл, иргэний гэр бүлийн байдлын 8 төрлийн бүртгэлийн бүрдүүлбэр материалын нийт 4086 бүртгэлд хяналт шалгалт хийхэд зөчил

дутагдал илрээгүй. Хяналт шалгалтын газрын 2021 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 8/2473 тоот чиглэлийн хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, 25.2 дахь хэсэгт заасны дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын “Иргэний шилжилт хөдөлгөөнийг түр зогсоох тухай” 2021 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн А/215 дугаар тушаал гарсантай холбогдуулан шилжилт хөдөлгөөний бүртгэлийн нотлох баримтыг хянаж, эх нотлох баримт болон ИУБ-22 маягтыг тулган шалгаж иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд хуулийн хугацаанд үнэн зөв шивж, баталгаажуулсанд хяналт тавиж ажилласан. Мөн 15 сумын улсын бүртгэгч нараар шилжилт хөдөлгөөний бүртгэлийн дэвтэрт “шилжилт хөдөлгөөний бүртгэл түр зогсоосон” тухай тэмдэглэгээ хийлгэж, ИУБ-22 маягтын хамт 2021 оны 04 дүгээр сарын 10, 11 ний өдрүүдэд УБХэлтэст ирүүлснийг лацдаж, Иргэний улсын бүртгэлийн архивт хадгалсан. Тус аймагт бүртгэгдсэн нийт 787 иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийн бүрдүүлбэр материалыг тухай бүр нягтлан шалгаж Хяналт шалгалтын газарт хүргүүлсэн. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 19.6.1, 19.6.2, 19.6.3 дагуу “Түр хасав” нэмэлт тэмдэглэгээтэй 670 сонгогчийн нэр, 19.6.4, 19.6.5, 19.6.7 дагуу 942 сонгогчийн нэр, үндсэн 44739 онгогчийн нэрийг хэвлэх үйл явцад хяналт шалгалтыг хийсэн. Хяналт шалгалтын батлагдсан удирдамжийн дагуу 2021 оны 06 дугаар сарын 14-16 ны хооронд хөдөөгийн 14 сумын Улсын бүртгэгч нарын иргэний 8 төрлийн бүртгэлийн бүрдүүлбэр нийт 403 материалыг шалгаж, 6 зөрчлийг илрүүлж газар дээр нь арилгуулах арга хэмжээг авч, холбогдох зөвлөгөөг мэдээллийг өгч ажилласан.

ХЭУБүртгэл: Хуулийн этгээдийн оноосон нэрийн бүртгэл, нэмэлт өөрчлөлтийн бүртгэлийн мэдээллийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн ERS програмд хандах эрхийн дагуу орж бүртгэлүүдийг өдөр тутам хянаж байна. Тайлангийн хугацаанд шинээр үүсгэн байгуулагдсан болон нэмэлт өөрчлөлт орсон нийт 107 бүртгэлийн бүрдүүлбэр материалын архивын хувийн хэрэг дэх эх нотлох баримтыг татан авч шалгахад зөрчил дутагдал илрээгүй, бүгд бүртгэлийн бүрдүүлбэр хангасан нотлох баримтууд байсан. Мөн хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн 720 бүртгэлд хяналт шалгалтыг хийхэд зөрчил дутагдал илрээгүй.

Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтөө хуулийн хугацаанд бүртгүүлээгүй Зөрчлийн тухай хуулийн 15.23.1.1 дэх хэсэгт зааснаар торгуулийн арга хэмжээ авагдсан "Тавантогой"ХК, "Өмнөговь аймгийн Эрдмийн гэгээ сургуулийн ажиллагсадын ҮЭХороо" "Ханбогд вейст менежмент центр"ХХК, "Даланзадгад зорчигч тээвэр"ОНӨААТҮГ мөн хуулийн этгээдийн тамга тэмдгээ хаяж үрэгдүүлсэн "Өмнөговь аймгийн боксын холбоо"НҮТББ, "Онъст хүрд"ХХК, "Их заяат эрдэнийн уул"ХХК, "Бэсүд тайж"ХХК зөрчлийн тухай хуулийн 10.20 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу 500 нэгжээр торгон, хуучин хяналтын дугаарыг хүчингүй болгосон дүгнэлтийг тус тус үйлдэж Хяналт шалгалтын газарт хүргүүлэн зөрчлийг бүрэн арилгасан.

ЭХЭУБүртгэл: ЭХЭУБүртгэлийн ePRS програмд хандах эрхийн дагуу орж бүртгэлийн бүрдүүлбэр материалуудыг түүвэрчлэн шалгаж байна. Тайлангийн хугацаанд газар өмчлөх эрхийн бүртгэл, барьцаат зээлийн гэрээ, БЗГэрээ дуусгавар болгосон, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн анхны бүртгэлийн нийт 167 бүртгэлийн бүрдүүлбэр материалыг шалгахад ямар нэгэн зөрчил дутагдал илрээгүй.

Үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлийн гэрчилгээг хаяж үрэгдүүлсэн эрхийн улсын бүртгэлийн Ү-1112000115, Г-1112000117, Г-1112001014, Г-1112000119, Ү-1112000234, Ү-1105002667, Г-1107000316, Г-1105000670, Ү-1105003191, Г-1103000123, Г-1101000075, Г-1105004294, Г-1105003616, Г-1105004676, Г-1104000231, Г-1105001847, Ү-1105000239, Г-1105004815, Ү-1104000206, Г-1105000585, Ү-1105001292 дугаартай бүртгэлүүдэд Хяналтын улсын байцаагчийн дүгнэлт үйлдэж Хяналт, шалгалтын газарт хүргүүлэн, зөрчлийг арилгасан.

Бусад:

- 2021 оны 01 дүгээр сарын 05 нд Улсын бүртгэлийн хэлтсээс зохион байгуулсан сумын улсын бүртгэгч нарт зориулсан цахим сургалтанд оролцож, Хяналт шалгалтын талаар мэдээлэл хүргэсэн.
- 2021 оны 01 дүгээр сарын 22 нд УБЕГазраас зохион байгуулсан “Төрийн албан хаагчийн гүйцэгэлийн төлөвлөгөө боловсруулах, үнэлэх аргачлал” сэдэвт online сургалтанд хамрагдсан.
- 2021 оны 01 дүгээр сарын 27 нд УБЕГазраас зохион байгуулсан “Гадаад паспортыг гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгах” талаарх online сургалтанд хамрагдсан.
- 2021 оны 03 дугаар сарын 23 нд МУЗГазар, НҮБ, Канадын элчин сайдын яам, Төрийн албаны зөвлөлөөс хамтран зохион байгуулсан “Эмэгтэйчүүдийн манлайлал” сэдэв web семинарт хамрагдсан.
- 2021 оны 04 дүгээр сарын 08 нд Өмнөговь аймаг дахь Төрийн албаны салбар зөвлөлөөс зохион байгуулсан “E-Mongolia цахим үйлчилгээний систем”-ийн талаарх цахим сургалтанд хамрагдсан.
- 2021 оны 04 дүгээр сарын 08 нд УБЕГазрын Хяналт шалгалтын газраас зохион байгуулсан “Эрхийн улсын бүртгэлд урьдчилсан тэмдэглэл хийх хүчингүй болгох, ХЭУБүртгэлд хориг тавих цуцлах бүртгэлд анхаарах асуудлууд” сэдэвт цахим сургалтанд хамрагдсан.
- 2021 оны 04 дүгээр сарын 19 нд УБЕГазраас зохион байгуулсан Аудит, шилэн дансны талаарх цахим сургалтанд хамрагдсан.
- 2021 оны 05 дугаар сарын 10 нд УБЕГазраас зохион байгуулсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн талаарх цахим сургалтанд хамрагдсан.
- 2021 оны 05 дугаар сарын 10 нд Өмнөговь аймгийн Татварын хэлтэсээс “Татвар төлөгчдийн өдрийг тохиолдуулан” зохион байгуулсан цахим сургалтанд оролцож хуулийн этгээтэй холбоотой Зөрчлийн тухай хуулиар мэдээлэл хүргэв.
- 2021 оны 05 дугаар сарын 12 нд УБЕГазраас зохион байгуулсан “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуул”-ийн эрх зүйн цахим сургалтанд хамрагдсан.
- 2021 оны 06 дугаар сарын 01 нд Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн 14 дүгээр тойргийн 61 хэсгийн хорооны санал авах байрны дэргэд ажиллах Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтануудад зориулсан эрх зүйн болон програмын 2 өдрийн сургалтанд бүрэн хамрагдсан.
- 2021 оны 06 дугаар сарын 03 нд Аймгийн Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 09-ний А/402 тоот захирамжаар байгуулагдсан “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох хуулийн этгээдийн эрх зүйн зохицуулал”-ын талаарх ажлын хэсгийн хуралд оролцсон.

- 2021 оны 06 дугаар сарын 07 нд УБЕГазрын ЭХЭУБГазраас зохион байгуулсан ЭХЭУБүртгэгч нарт зориулсан цахим сургалтанд хамрагдсан.
- 2021 оны 06 дугаар сарын 09 нд Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн 14-р тойргийн 1-7 дугаар хэсгийн хороонд Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажилласан.

**Өмнөговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн
2021 оны эхний хагас жилийн тээвэр гаргасан**

- | | |
|-----------------------------|--|
| 1. Ч.Энхмөнх | - Улсын бүртгэлийн хэлтсийн дарга |
| 2. Д.Наранбилэг | - Хяналтын улсын байцаагч |
| 3. Б.Должинсүрэн | - ИУБТасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч |
| 4. Б.Азжаргал | - ЭХЭБТасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч |
| 5. З.Хасар | - Иргэний бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч |
| 6. Ч.Пүрэвдавга | - Иргэний бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч |
| 7. Т.Нямсамбуу | - ЭХЭБТасгийн улсын бүртгэгч |
| 8. М.Оюун-Эрдэнэ | - ЭХЭБТасгийн улсын бүртгэгч. |
| 9.М.Энхтогтох | - Хуулийн этгээдийн улсын бүртгэгчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч |
| 10. С.Батхүү | - Ахлах нягтлан бодогч |
| 11. А.Цэцэгдэлгэр | - ИБТасгийн архивчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч |
| 12. А.Цэцэгжаргал | - ЭХЭБТасгийн архивч |
| 13. С.Ариунсайхан | - Даланзадгад сумын улсын бүртгэгч |
| 14. М.Түвшинжаргал | - Даланзадгад сумын улсын бүртгэгч |
| 15. О.Эрдэнэбат | - Мэдээллийн технологийн ажилтан, нярав |
| 16. О.Жижигчулуун | - Архив, Бичиг хэргийн ажилтан |
| 17. Сумын 14 улсын бүртгэгч | |

ТАЙЛАНГ НЭГТГЭЖ ХЯНАСАН:

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА Ч.ЭНХМӨНХ